

70



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 06 сарын 21 өдөр

Дугаар 74

Номгон

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
ээлжит III хуралдааны тов зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 71 дүгээр тогтоолоор тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдааныг 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 10:00 цагт цахим хэлбэрээр хуралдуулахаар товлон зарлаж, хэлэлцэх асуудлыг хавсралтаар баталсугай.

2. Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулах бэлтгэлийг сайтар хангаж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов), аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 06 дугаар сарын 21-ний
өдрийн 74 дүгээр тогтоолын хавсралт

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ III ХУРАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

- 1.1. Аймгийн эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал, цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл
- 1.2. Боловсролын салбарын өнөөгийн байдлын талаарх танилцуулга, мэдээллийн тухай
- 1.3. Эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдлын талаарх танилцуулга, мэдээллийн тухай
- 1.4. Хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдлын талаарх танилцуулга, мэдээллийн тухай
- 1.5. Аймгийн хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын өнөөгийн байдлын танилцуулга, мэдээллийн тухай
- 1.6. Онцгой нөхцөл байдал үүсч бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Онцгой комисст ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас хандивласан тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлангийн тухай
- 1.7. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө, түүний зарцуулалтын тайлангийн тухай
- 1.8. Аймгийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, 2020 оны төсвийн үлдэгдэл хуваарилах, 2021 оны төсөвт зохицуулалт хийх тухай
- 1.9. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороодын тоо, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай
- 1.10. “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын цалингийн сан, бусад зардлыг нэмэгдүүлэх тухай
- 1.11. “Тээврийн хэрэгсэл түр саатуулах хашаа” (байр)-ны төлбөрийн хэмжээг тогтоох тухай
- 1.12. Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтын төвийн төлбөр, үнэ тарифыг батлах тухай
- 1.13. “Ингэн эрдэнэ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байгуулж, дүрэм батлах тухай
- 1.14. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлуулах тухай
- 1.15. Аймгийн Засаг даргын Тамгын газрын эзэмшилд буй “Корунд гео” ХХК-ний 20 хувийн хувьцааг шилжүүлэх тухай